

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1.Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндэс, баталгаа болон шүүхийн захиргааны чиг үүрэг, ажиллах журмыг тогтоох болон шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Шүүхийн тухай хууль тогтоомж

2.1.Шүүхийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, /цаашид “Үндсэн хууль” гэх/ энэ хууль, Шүүгчийн эрх зүйн байдал, сахилга, хариуцлагын тухай хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“шүүх” гэж Үндсэн хууль болон энэ хуульд заасны дагуу байгуулагдан хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж, заавал биелүүлэх шийдвэр гаргадаг шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг;

3.1.2.“дагнасан шүүх” гэж эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулагдсан шүүхийг.

4 дүгээр зүйл.Шүүхийн эрхэм зорилго

4.1.Шүүх нь дараах эрхэм зорилготой:

4.1.1.Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, Үндсэн хуульд байгууллыг бататган хамгаалах;

4.1.2.хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох;

4.1.3.хууль дээдлэх, шударга ёс, ардчилсан ёсыг бэхжүүлэх;

4.1.4.хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, эрх зүйн ухамсар, соёлыг дэлгэрүүлэх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ

5 дугаар зүйл.Шүүхийн тогтолцооны нэгдмэл байдал

5.1.Шүүхийн тогтолцоо нь нэгдмэл байх бөгөөд шүүх зохион байгуулалтын хувьд бие даасан байна.

5.2.Шүүхийн тогтолцоо, зохион байгуулалтыг Үндсэн хууль болон энэ хуулиар тогтоох замаар шүүхийн тогтолцооны нэгдмэл байдлыг хангана.

5.3.Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү Үндсэн хууль болон энэ хуульд заасны дагуу байгуулагдсан шүүх хэрэгжүүлнэ.

5.4.Аливаа шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Монгол Улсын дээд шүүх /цаашид “Улсын дээд шүүх” гэх/-ийн хяналтаас гадуур байж үл болно.

6 дугаар зүйл.Шүүхийн бие даасан байдал

6.1.Шүүх эрх мэдэл бүрэн эрхээ хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлээс хараат бусаар бие даан хэрэгжүүлнэ.

6.2.Шүүх нь Үндсэн хууль болон бусад хуульд захирагдаж, аливаа этгээдийн хүсэл зоригоос хараат бус байж шүүх эрх мэдлийг бие даан хэрэгжүүлнэ.

6.3.Шүүхийн бие даасан байдлын зарчмыг алдагдуулсан, дордуулсан хууль тогтоомж болон захиргааны акт гаргахыг хориглоно.

6.4.Бүх шатны шүүхийн шүүгч болон Ерөнхий шүүгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шүүгчийн шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, энэхүү ажиллагаатай холбоотой заавар өгөх, удирдамжаар хангах, шүүгчид тодорхой хэрэг, маргааныг нэр заан хуваарилах зэргээр шүүгчийн хараат бус байдалд халдахыг хориглоно.

6.5.Шүүх өөрийн захиргаатай байх ба түүний чиг үүргийг Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн тамгын газар хэрэгжүүлэх бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.

6.6.Шүүх эрх мэдэл хөгжлийн бодлоготой байх бөгөөд түүнийг Шүүхийн ерөнхий зөвлөл хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, Засгийн газартай зөвшилцөн Улсын Их Хуралд уламжилж, батлуулна.

6.7.Бүх шатны шүүхийн шүүгчийн орон тоо, цалингийн хэмжээг Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурал тогтооно.

6.8.Шүүх нь шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах үүрэг бүхий шүүхийн ажилтантай байх бөгөөд шүүхийн ажилтны эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

6.9.Шүүх нь Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу нийлүүлэх эд хөрөнгө, зээл, тусламж, олон улсын болон хүмүүнлэгийн тусламжийн төсөл, хөтөлбөрөөс бусад гадаад, дотоодын иргэн, хуулийн этгээдээс аливаа хэлбэрээр хандив, санхүүгийн туслалцаа авахыг хориглоно.

7 дугаар зүйл.Шүүх хууль дээдлэх, гагцхүү хуульд захирагдах

7.1.Хууль дээдлэх нь шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.

7.2.Шүүхээр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

7.3.Шүүх хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ албан ёсоор нийтлэгдсэн хүчин төгөлдөр хууль, Монгол Улсын олон улсын гэрээг хэрэглэнэ.

7.4.Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль, Монгол Улсын олон улсын гэрээ нь Үндсэн хуульд нийцээгүй гэж шүүх үзвэл тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, уг хууль, Монгол Улсын олон улсын гэрээний талаарх саналаа Улсын дээд шүүхэд гаргана.

8 дугаар зүйл.Шүүхийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх

8.1.Шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй, ил тод байна.

8.2.Шүүх хуралдааныг хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд нээлттэй явуулна.

8.3.Шүүх хуралдааныг нээлттэй явуулах нөхцөл, шаардлагыг хангасан шүүх хуралдааны танхимын зохион байгуулалт, стандартыг Шүүхийн ерөнхий зөвлөл баталж, мөрдүүлнэ.

8.4.Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ ил тод байдал, шудрага ёс, олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор иргэдийн төлөөлөгчийг энэ хуульд заасан журмын дагуу оролцуулна.

8.5.Шүүх хуралдааны явцыг дуу болон дуу-дүрсний бичлэгээр баталгаажуулж архивт хадгална. Шүүгч буюу шүүх бүрэлдэхүүн шаардлагатай гэж үзсэн, эсхүл хэргийн оролцогчоос хүсэлт гарсан бол дуу болон дуу-дүрсний бичлэгийг зохих журмын дагуу баталгаажуулж болно.

8.6.Шүүх бүр өөрийн цахим хуудастай байж, шийдвэр, үйл ажиллагаагаа нийтэд тогтмол мэдээлж байна.

8.7.Энэ хуулийн 8.6-д зааснаар шүүхийн шийдвэрийг мэдээлэхдээ төрийн болон албаны, хувь хүн, хуулийн этгээдийн хуулиар хамгаалагдсан нууцлалыг хангана.

9 дүгээр зүйл.Мэтгэлцэх зарчим

9.1.Шүүн таслах ажиллагааг мэтгэлцэх зарчмын үндсэн дээр явуулна.

9.2.Шүүх шүүн таслах ажиллагааны явцад шүүгдэгч, хохирогч, нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч, прокурор болон бусад оролцогчдыг шүүх хуралдаанд мэтгэлцэх эрхээ хэрэгжүүлэх боломжоор тэгш хангана.

9.3.Энэ хуулийн 9.2-т заасныг зөрчсөн нь шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

9.4.Шүүх хуралдааны үеэр мэтгэлцэх журмыг хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх холбогдох хуулиар зохицуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ШҮҮХ

10 дугаар зүйл.Шүүхийн тогтолцоо

10.1.Шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэнэ.

10.2.Анхан болон давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг тойргийн зарчмаар байгуулахад иргэн шүүхэд хандах эрхийн баталгааг хангах, шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, шүүхийн үйлчилгээг иргэнд хүртээмжтэй хүргэхэд чиглэсэн байна.

10.3.Улсын дээд шүүхээс бусад шүүхийг энэ хуулийн 10.1, 10.2-т заасны хүрээнд эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулах зарчим баримтална.

11 дүгээр зүйл.Шүүх байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах

11.1.Монгол Улсад шүүхийг Үндсэн хууль болон энэ хуульд заасан журмын дагуу зөвхөн хуулиар байгуулж, өөрчлөн байгуулж, татан буулгах бөгөөд Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд шүүхийн бүрэлдэхүүнд хуулиар өөрчлөлт оруулж болно.

11.2.Улсын дээд шүүхийг Үндсэн хуульд заасан журмын дагуу байгуулна.

11.3.Улсын дээд шүүхээс бусад шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах тухай хуулийн төслийг Шүүхийн ерөнхий зөвлөл Засгийн газартай зөвшилцөн санал болгосноор Монгол Улсын Ерөнхийлөгч /цаашид “Ерөнхийлөгч” гэх/ Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

12 дугаар зүйл.Шүүхийн бүрэлдэхүүн

12.1.Бүх шатны шүүх нь Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.

12.2.Шүүхийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч тэргүүлнэ.

12.3.Үндсэн хууль, Шүүгчийн эрх зүйн байдал, сахилга, хариуцлагын тухай хуульд заасны дагуу Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно.

12.4.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн, Улсын дээд шүүхийн танхимын тэргүүнийг тухайн шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн тус тус өргөн мэдүүлснээр Ерөнхийлөгч гурван жилийн хугацаагаар томилох бөгөөд тухайн шүүхэд нэг удаа улируулан томилж болно.

12.5.Ерөнхий шүүгч, танхимын тэргүүний тусгайлсан бүрэн эрхийг энэ хуулиар, шүүгчийн нийтлэг бүрэн эрхийг Шүүгчийн эрх зүйн байдал, сахилга, хариуцлагын тухай хуулиар, шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдсон тодорхой бүрэн эрхийг хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх холбогдох хуулиар тус тус зохицуулна.

12.6.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн түр эзгүйд түүнийг тухайн шүүхэд хамгийн олон жил шүүгчээр ажиллаж байгаа танхимын тэргүүн, бусад шүүхийн Ерөнхий шүүгчийн түр эзгүйд түүнийг тухайн шүүхэд хамгийн олон жил шүүгчээр ажиллаж байгаа шүүгч тус тус орлоно.

12.7.Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч адил шатны өөр шүүхэд томилолтоор ажиллаж болно. Томилолтоор ажиллах нийтлэг журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.

13 дугаар зүйл.Ерөнхий шүүгчийн бүрэн эрх

13.1.Ерөнхий шүүгч дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.1.тухайн шүүхийг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;

13.1.2.энэ хуулийн 14.1-д заасан шүүгчдийн зөвлөгөөнийг товлон зарлах, хуралдуулах, удирдах, гарсан шийдвэрийн биелэлтийг хангуулах;

13.1.3.шүүх хуралдааныг даргалах, хуульд өөрөөр заагаагүй бол шүүх хуралдаан даргалагч болон шүүх бүрэлдэхүүнийг томилсон шийдвэрийг албажуулах;

13.1.4.иргэдийг хүлээн авах ажлыг хуулийн дагуу зохион байгуулах;

13.1.5.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;

13.1.6.шүүхийн тоон мэдээлэлд үндэслэн шүүн таслах ажиллагааны чанар, үр дүнгийн талаар Шүүгчдийн зөвлөгөөнд мэдээлэл хийх.

13.2.Ерөнхий шүүгч эрх хэмжээнийхээ асуудлаар захирамж гаргана.

14 дүгээр зүйл.Шүүгчдийн зөвлөгөөн

14.1.Шүүхэд тухайн шүүхийн нийт шүүгчээс бүрдсэн шүүгчдийн зөвлөгөөн ажиллана.

14.2.Шүүгчдийн зөвлөгөөн тогтмол хуралдаж, дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

14.2.1.тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн дотоод ажлын зохион байгуулалт, журмыг шүүхийн тамгын газартай хамтран тогтоох;

14.2.2.шүүх хуралдаан даргалагчийн дарааллыг тогтоох;

14.2.3.хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгчийг болон шүүх бүрэлдэхүүнээр шийдвэрлэх хэрэгт оролцох шүүгчийг томилох дарааллыг тогтоох;

14.2.4.шүүгчийг мэргэшүүлэх сургалтын саналаа Шүүхийн ерөнхий зөвлөлд уламжлах;

14.2.5.Шүүхийн ерөнхий зөвлөлөөс баталсан хэрэг хуваарилах нийтлэг журмын дагуу шүүхийн хэрэг хуваарилах нарийвчилсан журмыг батлах;

14.2.6.энэ хуулийн 13.1.6-д заасан мэдээлэлтэй танилцах;

14.2.7.хуульд заасан бусад бүрэн эрх.

14.3.Тухайн шүүхийн шүүгчдийн олонхийн саналаар шүүгчдийн ээлжит бус зөвлөгөөнийг зарлан хуралдуулж болно.

14.4.Шүүгчдийн зөвлөгөөн Ерөнхий зөвлөлөөс баталсан нийтлэг дэгийн хүрээнд хуралдааныхаа дэгийг тогтооно.

14.5.Шүүгчдийн зөвлөгөөн энэ хуулийн 14.2-т заасан асуудлыг зөвлөгөөнд оролцсон шүүгчдийн олонхийн саналаар шийдвэрлэж тогтоол гаргах бөгөөд уг тогтоолын биелэлтийг Ерөнхий шүүгч зохион байгуулна.

14.6.Энэ хуулийн 14.2.5-д заасан журам нь урьдчилан мэдэх боломжгүй, тохиолдлоор хуваарилах нөхцөлийг хангасан байх бөгөөд энэ шаардлагыг цахим програм хангамж ашиглан хэрэгжүүлж болно.

15 дугаар зүйл.Шүүгчдийн нэгдсэн зөвлөгөөн

15.1.Шүүгчдийн нэгдсэн зөвлөгөөнд Монгол Улсын шүүхийн нийт шүүгчид оролцох эрхтэй.

15.2.Шүүгчдийн нэгдсэн зөвлөгөөн хоёр жил тутам хуралдах бөгөөд дараагийн хурлын товоо өөрөө тогтооно. Шүүгчдийн нэгдсэн зөвлөгөөнийг технологийн тусламжтайгаар нэг цаг хугацаанд зайнаас буюу эсхүл бүсчилсэн байдлаар зохион байгуулж болох бөгөөд аль ч тохиолдолд хэлэлцэх асуудал нэг байна.

15.3.Шүүгчдийн нэгдсэн зөвлөгөөний зохион байгуулалтын ажлыг Монголын Хуульчдын холбооны Шүүгчдийн хороо /цаашид “Шүүгчдийн хороо” гэх/ Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран хариуцах бөгөөд шүүгчдийн олонхи оролцсоноор нэгдсэн зөвлөгөөн хүчинтэйд тооцогдоно.

15.4.Шүүгчдийн нэгдсэн зөвлөгөөнөөр дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

15.4.1.хуульд заасан албан тушаалд сонгох буюу сонгогдох шүүгчийн эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагааны журмыг батлах;

15.4.2.хуульд заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох шүүгчийг сонгох, эгүүлэн татах;

15.4.3.Шүүгчийн ёс зүйн дүрмийг хэлэлцэх, батлах;

15.4.4.шүүх эрх мэдлийн хүрээнд дагаж мөрдөх хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чиглэсэн саналыг Улсын дээд шүүхэд уламжлах;

15.4.5.шүүхийн үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлыг авч хэлэлцэх, хуульд заасан чиг үүрэгтэй нь холбоотой асуудлаар Шүүхийн ерөнхий зөвлөлд зөвлөмж гаргах;

15.5.Шүүгч энэ хуулийн 15.4.2-т заасны дагуу сонгогдож, зохих журмын дагуу томилогдон ажиллаж байгаа Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн

сахилгын хорооны гишүүнийг эгүүлэн татах хуульд заасан үндэслэл бүрдсэн гэж үзвэл өөрийн санал, дүгнэлтийг Шүүгчдийн нэгдсэн зөвлөгөөн болох өдрөөс 15-аас доошгүй хоногийн өмнө Шүүгчдийн хороонд хүргүүлнэ.

15.6.Шүүгч аливаа дарамт, шахалтаас өөрийгөө хамгаалах зорилгоор энэ хуулийн 15.5-т заасан санал, дүгнэлтийг нууцаар гаргаж болох бөгөөд шүүгчийн нууцаар гаргах санал, дүгнэлтийг Монголын Хуульчдын холбооны Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудал эрхэлсэн хороо Шүүгчдийн нэгдсэн зөвлөгөөн болох өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө хүлээн авч, нууцлалыг зохих журмын дагуу хангасны үндсэн дээр Шүүгчдийн хороонд 15 хоногийн дотор шилжүүлнэ.

15.7.Шүүгчдийн хороо энэ хуулийн 15.5, 15.6-д заасан шүүгчийн санал, дүгнэлтийг хэлэлцэх асуудлын дараалалд оруулж, үндэслэлийг Шүүгчдийн нэгдсэн зөвлөгөөнөөр заавал хэлэлцүүлнэ.

15.8.Энэ хуулийн 15.6-д заасны дагуу санал, дүгнэлт гаргасан шүүгчийг нууцлан хамгаалах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах бөгөөд шүүгчийн санал, дүгнэлтийг Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан нууцад хамааруулна.

15.9.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, эсхүл бусад шүүхийн Ерөнхий шүүгчдийн олонхи санал гаргасан тохиолдолд Шүүгчдийн нэгдсэн зөвлөгөөнийг ээлжит бусаар зохион байгуулж болох бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны гишүүнийг нөхөн томилох шаардлага үүссэн тохиолдолд нэн даруй зохион байгуулна.

15.10.Шүүгчдийн нэгдсэн зөвлөгөөнийг амралтын өдөр зохион байгуулах бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны гишүүнд нэр дэвших шүүгчийг сонгох, эгүүлэн татах асуудлыг нууц санал хураалтаар шийдвэрлэнэ. Шүүгчдийн нэгдсэн зөвлөгөөнд оролцсон шүүгчдийн олонхийн саналаар бусад асуудлыг нууц санал хураалтаар шийдвэрлэж болно.

15.11.Шүүгчдийн нэгдсэн зөвлөгөөнөөр хэлэлцсэн асуудлыг оролцсон шүүгчдийн олонхийн саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана.

15.12.Шүүгчийн ёс зүйн дүрмийн шинэчилсэн найруулгын болон нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулах, тухайн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлыг Шүүгчдийн хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран хариуцна.

16 дугаар зүйл.Шүүхийн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас

16.1.Шүүх соёмбо, өөрийн нэр бүхий тамга, тогтоосон загвараар үйлдсэн тэмдэгтэй байна.

16.2.Шүүх албан бичгийн болон шүүхийн шийдвэрийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд албан хэрэг хөтлөх журамтай байна.

17 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр

17.1.Шүүх шийдвэрээ Монгол Улсын нэрийн өмнөөс гаргана.

17.2.Шүүхийн шийдвэрийг бичих аргачлал, журмыг Улсын дээд шүүх тогтооно.

17.3.Шүүх захиргааны зөрчил, хэрэг, маргааныг хянан хэлэлцээд дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

17.3.1.анхан шатны шүүх шийтгэх ба цагаатгах тогтоол, шүүхийн шийдвэр, шүүгч шийтгэвэр;

17.3.2.давж заалдах шатны шүүх магадлал;

17.3.3.хяналтын шатны шүүх тогтоол.

17.4.Энэ хуулийн 17.3-т зааснаас бусад тохиолдолд хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.

17.5.Шүүх хамтын зарчмаар хэрэг, маргааныг хянан хэлэлцэхдээ олонхын саналаар шийдвэр гаргах ба цөөнх болсон шүүгч тусгай саналаа, хэрэв хэд хэдэн шүүгч тусгай саналтай бол тэдгээрийг нэгтгэж шүүхийн шийдвэрт хавсаргана.

17.6.Бүх шатны шүүх шийдвэрээ өөрийн цахим хуудсанд байршуулж, хэвлэн нийтэлнэ.

17.7.Хяналтын шатны шүүх нь шүүхийн нээлттэй, ил тод байдлыг хангах зорилгоор энэ хуулийн 17.5-д заасан тусгай саналыг зөвлөлдөх тасалгааны нууцыг задруулахгүйгээр өөрийн цахим хуудсанд байрлуулж, хэвлэн нийтэлж болно.

18 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх

18.1.Шүүхийн шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хувь хүн, үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй.

18.2.Шүүхийн шийдвэрийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадан гүйцэтгэнэ.

18.3.Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг санаатай биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд нь зориуд саад учруулсан этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

18.4.Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан төрийн албан тушаалтан өөрийн албан үүрэгт хамаарах хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг санаатай биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд зориуд саад учруулсан бол тухайн албан тушаалтныг огцруулах буюу чөлөөлөх арга хэмжээ авна.

18.5.Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг санаатай биелүүлээгүй буюу биелүүлэхэд зориуд саад учруулсан төрийн албан тушаалтанд энэ хуулийн 18.4-т заасан арга хэмжээг авах хүсэлтийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага Улсын дээд шүүхэд гаргах бөгөөд Улсын дээд шүүх хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл зохих журмын дагуу тогтоол гаргаж, тухайн албан тушаалтныг томилсон болон сонгосон байгууллагад хүргүүлнэ.

18.6.Шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбогдсон бусад харилцааг хуулиар зохицуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ

19 дүгээр зүйл.Улсын дээд шүүх, түүний бүрэн эрх

19.1.Улсын дээд шүүх нь Монгол Улсын шүүхийн дээд байгууллага бөгөөд хяналтын шатны шүүх мөн.

19.2.Улсын дээд шүүх шүүн таслах ажиллагааны төрлөөр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх эрүү, иргэн, захиргааны хэргийн зэрэг дагнасан танхимтай байна.

19.3.Улсын дээд шүүх нь Ерөнхий шүүгч, хорин дөрвөөс доошгүй шүүгчээс бүрдэнэ.

19.4.Улсын дээд шүүхийн шүүгч энэ хуулийн 19.2-т заасан танхимын аль нэгд харьяалагдана.

19.5.Улсын дээд шүүх дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.5.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу хуулиар тусгайлан харьяалуулсан тохиолдолд хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх;

19.5.2.иргэн, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалтай холбогдуулан гаргасан талуудын гомдлыг хүлээж авах эсэхээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар тогтоосон журмын дагуу бие даан шийдвэрлэх

19.5.3.эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалтай холбогдуулан гаргасан талуудын гомдол, Улсын ерөнхий прокурор, эсхүл түүний

эрх олгосон прокурорын эсэргүүцлийн үндсэн дээр хяналтын журмаар хянан шийдвэрлэх;

19.5.4.шүүхийн шийдвэр, практикт үндэслэн хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа хууль санаачлагчид уламжлах;

19.5.5.Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах, нийтлэх;

19.5.6.хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх;

19.5.7.хуульд зааснаар танхим байгуулах;

19.5.8.энэ хуулийн 7.4-т заасан саналыг хэлэлцэж үндэслэлтэй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах;

19.5.9.Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх, гишүүнээс чөлөөлөх, эгүүлэн татах тухай санал гаргах;

19.5.10.Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, гишүүнээс чөлөөлөх, эгүүлэн татах тухай санал гаргах;

19.5.11.Хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн тогтоолд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч дүгнэлт гаргасан, эсхүл Улсын ерөнхий прокурор эсэргүүцэл бичсэн бол хэргийг хянан шийдвэрлэх;

19.5.12.бүх насаар нь хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэртэй хэргийг гомдол, эсэргүүцэл гарсан эсэхээс үл хамааран хянан шийдвэрлэх;

19.5.13.хуульд заасан бусад бүрэн эрх.

20 дугаар зүйл.Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаан

20.1.Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаан /цаашид “Нийт шүүгчдийн хуралдаан” гэх/-аар энэ хуулийн 19.5.4, 19.5.5, 19.5.6, 19.5.7, 19.5.8, 19.5.9, 19.5.10, 19.5.11, 19.5.12-д заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоол гаргана.

20.2.Нийт шүүгчдийн хуралдааныг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, түүний түр эзгүйд албан үүргийг нь орлон гүйцэтгэж байгаа Улсын дээд шүүхийн Танхимын тэргүүн даргална.

20.3.Нийт шүүгчдийн хуралдаанд Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсон бол хуралдааныг хүчинтэйд тооцно.

20.4.Нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Шүүгчдийн санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

20.5.Нийт шүүгчдийн хуралдаан дэгээ өөрөө тогтооно.

21 дүгээр зүйл.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн бүрэн эрх

21.1.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч нь энэ хуулийн 13.1-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.1.1.танхимын тэргүүний ажлыг удирдах;

21.1.2.хуульд өөрөөр заагаагүй бол хэргийн харьяаллын талаар шүүх болон танхим хооронд гарсан маргааныг шийдвэрлэх;

21.1.3.шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй байх зайлшгүй нөхцөл үүссэн тохиолдолд Улсын дээд шүүхийн энэ хуулийн 19.5.1, 19.5.2, 19.5.3-т заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх зорилгоор шүүгчийг танхим харгалзахгүйгээр шүүх бүрэлдэхүүнд томилон ажиллуулах;

21.1.4.Улсын дээд шүүхийн тамгын газрын даргыг томилох, чөлөөлөх;

21.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.

22 дугаар зүйл.Улсын дээд шүүхийн танхимын тэргүүний бүрэн эрх

22.1.Танхимын тэргүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

22.1.1.танхимыг тэргүүлж, танхимын шүүгч, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын ажлыг удирдан зохион байгуулах;

22.1.2.танхимын эрхэлсэн шүүн таслах ажиллагааны төрлөөр иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх;

22.1.3.хуульд заасан журмын дагуу шүүх хуралдааныг даргалах;

22.1.4.Шүүгчийн эрх зүйн байдал, сахилга, хариуцлагын тухай хуулийн 11.1-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

22.1.5.хуульд өөрөөр заагаагүй бол хэргийн харьяалал тогтоох.

22.2.Танхимын тэргүүн бүрэн эрхийнхээ асуудлаар захирамж гаргана.

ТАВДУГААР БҮЛЭГ ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ

23 дугаар зүйл.Давж заалдах шатны шүүх, түүний бүрэн эрх

23.1. Давж заалдах шатны шүүхийн тогтолцоо нь дараахь бүтэцтэй байна:

- 23.1.1. аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх;
- 23.1.2. аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх;
- 23.1.3. аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх;
- 23.1.4. нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх;
- 23.1.5. нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх;
- 23.1.6. захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх.

23.2. Энэ хуулийн 23.1.1-д заасан шүүх нь шүүн таслах ажлын төрлөөр хэрэг маргааныг хянан шийдвэрлэх эрүүгийн болон иргэний хэргийн танхимтай байх бөгөөд тухайн шүүхийн шүүгч эдгээр танхимын аль нэгэнд харьяалагдаж ажиллана.

23.3. Давж заалдах шатны шүүх дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

23.3.1. анхан шатны шүүхийн шийдвэрийг хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн гаргасан гомдол, прокурорын эсэргүүцлийн үндсэн дээр давж заалдах журмаар хянан шийдвэрлэх;

23.3.2. хуулиар тусгайлан харьяалуулсан хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх;

23.3.3. давж заалдах шатны шүүхийн шүүн таслах ажиллагааны практикт үндэслэн хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа Улсын дээд шүүхэд уламжлах;

23.3.4. хуульд заасан бусад бүрэн эрх.

23.4. Энэ хуулийн 23.2-т заасан танхимыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор Улсын дээд шүүх тухайн Шүүхийн ерөнхий шүүгчтэй зөвшилцөн байгуулна. Танхимын тэргүүн нь энэ хуулийн 22.1-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

24 дүгээр зүйл. Давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн бүрэн эрх

24.1. Давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч энэ хуулийн 13.1-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

24.1.1. энэ хуулийн 23.3.1-д заасны дагуу хэрэг, маргааныг давж заалдах журмаар шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнийг шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцүүлж, томилсон шийдвэрийг албажуулах;

24.1.2.шүүн таслах ажлын чиглэлээр тодорхой хэргийн харьяаллын талаар анхан шатны шүүхийн хооронд гарсан маргааныг хянаж зохих харьяаллыг тогтоох;

24.1.3.тухайн шүүхийн шүүн таслах ажиллагаанд танхим харгалзахгүй оролцох;

24.1.4.хуульд заасан бусад бүрэн эрх.

24.2.Энэ хуулийн 23.1.1-д заасан шүүхийн Ерөнхий шүүгч нь шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй байх зайлшгүй нөхцөл үүссэн тохиолдолд Давж заалдах шатны шүүхийн энэ хуулийн 23.3.1, 23.3.2-т заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх зорилгоор шүүгчийг танхим харгалзахгүйгээр шүүх бүрэлдэхүүнд томилон ажиллуулах эрхтэй.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ АНХАН ШАТНЫ ШҮҮХ

25 дугаар зүйл. Анхан шатны шүүх

25.1. Анхан шатны шүүхийн тогтолцоо нь дараах бүтэцтэй байна:

- 25.1.1. дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх;
- 25.1.2. дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх;
- 25.1.3. захиргааны хэргийн анхан шатны шүүх;
- 25.1.4. сум буюу сум дундын шүүх;
- 25.1.5. сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх;
- 25.1.6. сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх.

25.2. Сум буюу сум дундын шүүхийг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно.

25.3. Анхан шатны шүүх тодорхой хэрэг, маргааны төрлөөр насанд хүрээгүй хүмүүсийн хэргийн, гэр бүлийн, хөдөлмөрийн маргааны зэрэг танхимтай байж болно.

25.4. Энэ хуулийн 25.3-т заасан танхимыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор Улсын дээд шүүх тухайн шүүхийн Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн байгуулна. Танхимын тэргүүн нь энэ хуулийн 22.1-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

25.5. Анхан шатны шүүх нь шүүн таслах ажлыг иргэдэд ойртуулах зорилгоор нүүдэллэн ажиллаж болох бөгөөд ийнхүү ажиллах нийтлэг журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.

25.6. Анхан шатны шүүх дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

25.6.1.хуулиар харьяалуулсан хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх;

25.6.2.анхан шатны шүүхийн шүүн таслах ажиллагааны практикт үндэслэн хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа Улсын дээд шүүхэд уламжлах;

25.6.3.хуульд заасан бусад бүрэн эрх.

26 дугаар зүйл. Анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн бүрэн эрх

26.1. Анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч нь энэ хуулийн 13.1-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

26.1.1. энэ хуулийн 25.6.1-д заасны дагуу хэрэг, маргааныг анхан шатны журмаар шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнийг шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцүүлж, томилсон шийдвэрийг албажуулах;

26.1.2. хуульд заасан бусад бүрэн эрх.

ДОЛДУГААР БҮЛЭГ ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БАТАЛГАА

27 дугаар зүйл. Шүүхийн бие даасан байдлыг хангах баталгаа

27.1. Шүүхийн бие даасан байдлыг хангах улс төр, хууль зүй, эдийн засгийн болон бусад баталгаа, нөхцөлийг төрөөс хангана.

28 дугаар зүйл. Шүүхийн улс төр, хууль зүйн баталгаа

28.1. Төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан, улс төрийн нам, хуулийн этгээд, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах ажиллагааны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, шууд болон шууд бусаар нөлөөлөхийг хориглоно.

28.2. Шүүгч, шүүх бүрэлдэхүүний хэрэг, маргаан шийдвэрлэхдээ гаргасан алдааны улмаас бусдад учирсан хохирлыг төр хариуцаж, улсын төсвөөс нөхөн төлнө.

28.3. Шүүхийг үл хүндэтгэсэн, шүүн таслах ажиллагаанд саад учруулсан, шүүхийн шийдвэрийг үл биелүүлсэн, шүүгч, иргэдийн төлөөлөгч, шийдвэр гүйцэтгэгчийг гүтгэсэн гэм буруутай этгээдэд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэж, зөрчигдсэн эрх, нэр төрийг нь Иргэний хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу сэргээнэ.

28.4.Шүүгч болон шүүхээс шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах чиг үүрэгтэй шүүхийн ажилтан нь улс төрийн нам, хөдөлгөөний гишүүн байхыг хориглоно.

29 дүгээр зүйл.Шүүхийн эдийн засгийн баталгаа

29.1.Бүх шатны шүүхийн шүүгчийн орон тоо нь шүүхийн бие даасан байдлыг хангаж, ажлын зохист ачааллын хүрээнд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд хүрэлцэхээр байна.

29.2.Шүүх бие даасан төсөвтэй байх бөгөөд Монгол Улсын шүүхийн төсөв нь улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.

29.3.Шүүхийн төсөв Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум, сум дундын, дүүргийн шүүх, дагнасан шүүхийн болон Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны төсвөөс тус бүрдэнэ.

29.4.Шүүхийн ерөнхий зөвлөл бүх шатны шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн улсын төсвийн төсөлд нэгтгүүлэхээр төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

29.5.Засгийн газар улсын төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ бүх шатны шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийн төслийг бүрэн тусгана.

29.6.Засгийн газар энэ хуулийн 29.4-т заасан төсвийн төсөлд өөрчлөлт оруулах саналтай бол санал, дүгнэлтээ тусгайлан боловсруулж, улсын төсвийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

29.7.Бүх шатны шүүхийн үйл ажиллагааны болон шүүхийн эдийн засгийн баталгааг хангахад зориулагдсан төсвийг өмнөх жилийнхээс бууруулахгүй бөгөөд Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг хэлэлцэн батлахдаа Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал, тайлбарыг сонсох, Засгийн газрын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэрлэнэ.

29.8.Шүүх нь гадаад, дотоодын хувь хүн, хуулийн этгээдээс аливаа хэлбэрээр хандив, санхүүгийн туслалцаа авахыг хориглох бөгөөд үүнд Монгол Улсын олон улсын гэрээгээр нийлүүлэх эд хөрөнгө, зээл, тусламж, олон улсын болон хүмүүнлэгийн тусламжийн төсөл, хөтөлбөр хамаарахгүй.

30 дугаар зүйл.Шүүхийн зохион байгуулалтын баталгаа

30.1.Шүүх өөрийн байртай байна.

30.2.Нүүдэллэн ажиллаж байгаа болон хуульд зааснаас бусад тохиолдолд шүүх хуралдааныг зөвхөн шүүх хуралдааны танхимд хийнэ.

30.3.Шүүх, шүүгч нь үйл ажиллагаагаа хараат бусаар явуулахад шаардагдах байнгын болон нүүдэллэн ажиллах байр, иргэдийг хүлээн авах болон шүүх хуралдааны танхим, тээвэр, холбоо, мэдээллийн болон тусгай зориулалтын техник хэрэгсэл, тавилга, тоног төхөөрөмж, хамгаалалтаар хангагдсан байх бөгөөд тэдгээрийн стандарт, нөхцөлийг Шүүхийн ерөнхий зөвлөл тогтооно.

30.4.Шүүхийн байранд шүүн таслах ажиллагаанаас өөр үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

31 дүгээр зүйл.Шүүхийн аюулгүй байдлын баталгаа

31.1.Шүүхийн байр төрийн хамгаалалтад байна.

31.2.Шүүх хуралдааны журам сахиулах, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, яллагдагчийг хуяглан хүргэх, шүүхийн дуудснаар ирэхгүй байгаа яллагдагч, гэрч, зохигч, хэргийн оролцогчийг албадан ирүүлэх, шүүхээс оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах үүргийг цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ.

31.3.Энэ хуулийн 31.2-т заасан үүргийг гүйцэтгэх журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

НАЙМДУГААР БҮЛЭГ ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

32 дугаар зүйл.Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн бүрэн эрх

32.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу анхан шатны шүүх хэрэг, маргааныг анхан шатны журмаар, хамтын зарчмаар хянан шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчийг оролцуулна.

32.2.Шүүхийн иргэдийн төлөөлөгч /цаашид “иргэдийн төлөөлөгч” гэх/ нь шүүн таслах ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор оролцоно.

32.3.Иргэдийн төлөөлөгч нь хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх анхан шатны шүүхийн хуралдаанд оролцохдоо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

32.3.1.шүүх хуралдааны үед тодруулах асуулт тавих замаар нотлох баримт шинжлэхэд оролцох;

32.3.2.шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр шүүгдэгч, зохигч, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, прокурор, гэрч, шинжээчид асуулт тавих;

32.3.3.хэргийн үйл баримтад үнэлэлт өгч, шүүгдэгч, зохигчийн гэм буруутай эсэх талаар бичгээр дүгнэлт гаргах;

32.3.4.хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

32.4.Иргэдийн төлөөлөгч нь эрүүл мэндийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас энэ хуулийн 32.3.3-т заасан дүгнэлтийг бичгээр гаргах боломжгүй бол энэ тухай шүүх хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлж, дүгнэлтийг амаар гаргаж болно.

32.5.Иргэдийн төлөөлөгч нь энэ хуулийн 32.3.3-т заасан дүгнэлтээ шүүх хуралдаанд уншиж сонсгоно.

32.6.Шүүх бүрэлдэхүүн шийдвэр гаргахдаа иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг харгалзан үзэх бөгөөд иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн талаарх үндэслэлээ шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт тодорхой тусгана.

32.7.Улсын дээд шүүх болон давж заалдах шатны шүүх нь хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг харгалзан үзэж, энэ хуулийн 32.6-д заасны дагуу шийдвэртээ тусгана.

32.8.Энэ хуулийн 32.6-д заасныг зөрчсөн нь шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох, шүүх бүрэлдэхүүнд оролцсон шүүгчдэд сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

32.9.Иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг шийдвэрийн тодорхойлох хэсэгт тусгана.

32.10.Иргэдийн төлөөлөгч нь шүүх хуралдаанаас өмнө хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, хуулийг дээдлэн, хэрэг, маргаан шийдвэрлэх ажиллагаанд хэнээс ч хараат бусаар оролцохоо батлан тангараглана.

32.11.Энэ хуулийн 32.10-т заасан тангараг өргөх журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.

33 дугаар зүйл.Иргэдийн төлөөлөгчид тавих шаардлага

33.1.Иргэдийн төлөөлөгч нь дараах шаардлага хангасан байна:

33.1.1.эрх зүйн бүрэн чадамжтай, 25 нас хүрсэн, 60 нас хүрээгүй Монгол Улсын иргэн байх;

33.1.2.тухайн анхан шатны шүүхийн харьяаллын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг байх;

33.1.3.эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй;

33.1.4.Иргэдийн төлөөлөгчөөр сонгогдох үедээ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон иргэний хэрэг хянан шийдвэрлэх, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэргийн оролцогч бус байх;

33.1.5.монгол хэлээр чөлөөтэй ярьж, ойлгодог байх;

33.1.6.сүүлийн нэг жилийн хугацаанд иргэдийн төлөөлөгчөөр шүүх хуралдаанд оролцоогүй байх.

33.2.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, шүүгч, шүүхийн ажилтан, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагч, тухайн орон нутагт үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн алба хаагч, онцгой байдлын албан хаагч, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргыг иргэдийн төлөөлөгчөөр сонгохгүй.

34 дүгээр зүйл.Иргэдийн төлөөлөгчийн үйл ажиллагаанд хориглох зүйл

34.1.Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх явцад иргэдийн төлөөлөгчийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

34.1.1.шүүх хуралдааныг орхин явах, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирэхгүй байх;

34.1.2.шүүх хуралдааны дэгийг сахин биелүүлэхгүй байх;

34.1.3.хэргийн оролцогч, түүний өмгөөлөгч, төлөөлөгчтэй уулзах;

34.1.4.хэргийн талаар нотлох баримт цуглуулах;

34.1.5.өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг задруулах;

34.1.6.хэвлэл мэдээллийн хэрэгсэлд иргэдийн төлөөлөгчөөр оролцсон хэргийн талаар мэдээлэл өгөх;

34.2.Энэ хуулийн 34.1 дэх хэсэгт заасан заалтын хэрэгжилтэд Шүүхийн ерөнхий зөвлөл хяналт тавьж, зөрчсөн этгээдийн иргэдийн төлөөлөгчөөр сонгогдох эрхийг хасна.

35 дугаар зүйл.Иргэдийн төлөөлөгчийн хараат бус байдал

35.1.Шүүгч, прокурор, өмгөөлөгч, хэргийн оролцогч болон бусад этгээдийн зүгээс иргэдийн төлөөлөгчид аливаа хэлбэрээр нөлөөлөхийг хориглоно.

35.2.Энэ хуулийн 35.1-д заасан нөхцөл байдал бий болсон гэж үзсэн тохиолдолд иргэдийн төлөөлөгч Шүүгчийн эрх зүйн байдал, сахилга, хариуцлагын тухай хуулийн 3.1.2-т заасан нөлөөллийн мэдүүлэг бөглөнө.

35.3.Энэ хуулийн 37.1-д заасны дагуу сонгосон иргэдийн төлөөлөгчийн нэрсийг шүүгч, шүүх хуралдаанаас өмнө задруулахыг аливаа этгээдэд хориглоно.

36 дугаар зүйл.Иргэдийн төлөөлөгчийн нэрийн жагсаалт

36.1.Шүүхийн ерөнхий зөвлөл иргэдийн төлөөлөгчийг сонгох журам, иргэдийн төлөөлөгчийг сургалтад хамруулах нэгдсэн төлөвлөгөөг тус тус батална.

36.2.Шүүхийн ерөнхий зөвлөлөөс тухайн орон нутгийн хүн амын тоог үндэслэн баталсан жишиг тоог харгалзан иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтыг тухайн орон нутгийн анхан шатны шүүхийн тамгын газраас нутгийн захиргааны байгууллагатай хамтран гаргана.

36.3.Энэ хуулийн 36.2-т заасны дагуу гаргасан иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалт нэг жил хүчинтэй байна.

36.4.Энэ хуулийн 36.3-т заасан хугацаа дуусахаас гурван сарын өмнө шүүхийн тамгын газар иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтыг шинэчлэх бэлтгэл ажлыг хийнэ.

36.5.Шүүхийн тамгын газар иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтад нэр нь орсон иргэнийг энэ хуулийн 33 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгаж, энэ хуулийн 41.1-д заасан мэдээллийн сан бүрдүүлнэ.

36.6.Энэ хуулийн 36.2-т заасны дагуу гаргасан иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтыг шүүхийн тамгын газрын дарга батална.

36.7.Шүүхийн ерөнхий зөвлөл нь иргэдийн төлөөлөгчийн оролцооны талаар судалгаа, дүн шинжилгээ, статистик мэдээг тогтмол гаргана.

37 дугаар зүйл.Иргэдийн төлөөлөгчийг сонгох

37.1.Энэ хуулийн 36.6-д заасан иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтаас иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах ажлыг тухайн шүүхийн тамгын газар зохион байгуулна.

37.2.Шүүх энэ хуулийн 36.6-д заасан нэрсийн жагсаалтаас долоо хоног тутам 10-15 хүний нэрсийн дэд жагсаалтыг цахим хэлбэрээр тохиолдлын журмаар гарган тухайн шүүхийн тамгын газрын даргаар батлуулна.

37.3.Шүүх хуралдааны тов зарлагдмагц энэ хуулийн 41.1-т заасан мэдээллийн санд нэр нь орсон шүүх хуралдаанд орох гурав, нөөцөд байх гурван иргэдийн төлөөлөгчийг шүүх хуралдаан тус бүрд цахимаар хуваарилна.

37.4.Шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэнд шүүх хуралдаан болохоос ажлын таваас доошгүй өдрийн өмнө мэдэгдэх хуудсаар мэдэгдэж, баримтыг хэрэгт хавсаргана.

37.5.Энэ хуулийн 37.4-т заасан шүүхийн мэдэгдэх хуудсыг хүлээн авсан иргэдийн төлөөлөгч энэ хуулийн 37.8-д заасан хүндэтгэн үзэх шалтгаантай бол энэ тухайгаа тухайн шүүхийн тамгын газарт нэн даруй мэдэгдэнэ.

37.6.Шүүхийн тамгын газар иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэний ажил олгогчид мэдэгдэл хүргүүлнэ.

37.7.Энэ хуулийн 37.6-д заасан ажил олгогч нь шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцох болсон ажилтандаа чөлөө олгож, аливаа байдлаар саад учруулахгүй байх үүрэг хүлээнэ.

37.8.Хуульд заасны дагуу татгалзан гараагүй бол дор дурдсан хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэнийг шүүх хуралдаанд оролцохоос зайлсхийсэн гэж үзэж түүнд энэ хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ:

37.8.1.эмнэлгийн магадлалаар баталгаажсан эрүүл мэндийн нөхцөл байдлын улмаас шүүх хуралдаанд оролцох боломжгүй болсон;

37.8.2.ажил олгогчийн баталгаажуулсан албан томилолттой байсан;

37.8.3.бага насны хүүхэд болон бусад этгээдийг асран хамгаалж байгаа бөгөөд энэ талаар хорооны Засаг даргын тодорхойлолттой бол;

37.8.4.хүндэтгэн үзэх бусад шалтгаантай байсан.

37.9.Иргэдийн төлөөлөгчийг сонгох үйл ажиллагаанд хүнийг үндэс угсаа, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, боловсролоор нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.

38 дугаар зүйл.Иргэдийн төлөөлөгчийг татгалзан гаргах

38.1.Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа иргэдийн төлөөлөгч өөрөө татгалзан гарах, эсхүл хэргийн бусад оролцогчдоос түүнийг татгалзах хүсэлт гаргасан бол шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэж тогтоол гаргана.

38.2.Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа иргэдийн төлөөлөгч өөрөө татгалзан гарах үндэслэлийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар тус тус тогтооно.

39 дүгээр зүйл.Иргэдийн төлөөлөгчийг мэдээллээр хангах

39.1.Шүүхийн тамгын газар иргэдийн төлөөлөгчдөд шүүх хуралдаанд оролцохоос нь өмнө эрх, үүрэг, хүлээх хариуцлага, шүүх хуралдааны дэгийн талаар мэдээлэл өгнө.

39.2.Шүүхийн ерөнхий зөвлөл иргэдийн төлөөлөгчдөд зориулсан цахим гарын авлага боловсруулж, холбогдох зөвлөгөө, мэдээллээр бүрэн хангана.

39.3.Тухайн жилд сонгогдсон иргэдийн төлөөлөгчдөд зориулсан сургалтыг Шүүхийн ерөнхий зөвлөл цахимаар зохион байгуулах бөгөөд цахим сургалтын хичээлийг албан ёсны цахим хуудсандаа жилийн турш байршуулж тухай бүр үзэж судлах боломжоор хангана.

39.4.Иргэдийн төлөөлөгчөөр оролцохын ач холбогдлыг иргэдэд ухуулан таниулах ажлыг Шүүхийн ерөнхий зөвлөл болон тухайн шүүхийн тамгын газар зохион байгуулна.

40 дүгээр зүйл.Иргэдийн төлөөлөгч оролцох

40.1.Хэрэг, маргааныг анхан шатны журмаар шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд 3 хүртэл иргэдийн төлөөлөгч оролцоно.

40.2.Энэ хуулийн 37.3-т заасан иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд оролцох боломжгүй бол нөөцөд байгаа иргэдийн төлөөлөгчдөөс оролцуулна.

41 дүгээр зүйл.Иргэдийн төлөөлөгчийн талаарх бүртгэл мэдээлэл

41.1.Шүүхийн тамгын газар зохих журмын дагуу тухайн жилийн иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалт бүхий мэдээллийн санг бүрдүүлж Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэх бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл нийт нэрийн жагсаалтыг нэгтгэсэн мэдээллийн нэгдсэн сан үүсгэж архивт бүртгэнэ.

42 дугаар зүйл.Иргэдийн төлөөлөгчийг ажиллах нөхцөлөөр хангах, хөлс олгох

42.1.Шүүхийн ерөнхий зөвлөл болон шүүхийн тамгын газар иргэдийн төлөөлөгчийн цагийг хэмнэх, зардал гаргуулахгүй байх зохист арга хэмжээг авч, ажиллах нөхцөлөөр хангана.

42.2.Иргэдийн төлөөлөгчийг ажиллах нөхцөлөөр хангах стандартыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.

42.3.Иргэдийн төлөөлөгчийн хөлс болон холбогдох бусад зардлыг тухайн шүүхийн төсөвт тусгаж, шүүхийн төсвөөс олгоно.

42.4.Иргэдийн төлөөлөгчид хөлс болон албан томилолт, замын зардал олгох журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ, ТҮҮНИЙ БҮРЭЛДЭХҮҮН, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

43 дугаар зүйл.Шүүхийн захиргаа

43.1.Шүүхийн захиргаа нь Шүүхийн ерөнхий зөвлөл /цаашид “Ерөнхий зөвлөл” гэх/, түүний ажлын алба, бүх шатны шүүхийн тамгын газар, судалгааны төв болон бусад туслах нэгжээс бүрдэнэ.

43.2.Шүүхийн захиргаа нь шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс хэрэг, маргааныг шийдвэрлэхэд арга зүй, мэдээлэл, судалгаа, санхүү, аж ахуй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэн, ажиллах нөхцөлөөр хангах үндсэн чиг үүрэгтэй байна.

44 дүгээр зүйл.Ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааны зарчим

44.1.Ерөнхий зөвлөл үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

- 44.1.1.бие даасан, хараат бус байх;
- 44.1.2.шүүн таслах ажиллагаанд оролцох, нөлөөлөхийг хориглох;
- 44.1.3.мэргэшсэн, тогтвортой байх;
- 44.1.4.шүүхийн үйлчилгээ шуурхай, хүртээмжтэй байх.

45 дугаар зүйл.Ерөнхий зөвлөл, түүний чиг үүрэг

45.1.Ерөнхий зөвлөл нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилго бүхий шүүхийн захиргааны төв байгууллага мөн.

45.2.Ерөнхий зөвлөл нь энэ хуулийн 43.2-т зааснаас гадна шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

45.2.1.шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах ажлыг нэгтгэн зохион байгуулах;

- 45.2.2.шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах;
- 45.2.3.шүүгчийг хуульчдаас шилж олох;
- 45.2.4.шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
- 45.2.5.шүүхийн санхүү, эдийн засгийн баталгааг хангах;
- 45.2.6.шүүхийн хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх;
- 45.2.7.шүүх болон олон нийтийг мэдээллээр хангах

45.3.Ерөнхий зөвлөл нь зөвхөн шүүгчийн хараат бус байдлыг хангах чиглэлд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлангаа Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанд Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүний 4 жилийн бүрэн эрхийн хугацаанд нэг удаа танилцуулна.

46 дугаар зүйл.Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах ажлыг нэгтгэн зохион байгуулах

46.1.Ерөнхий зөвлөл шүүхийн бие даасан байдлыг хангах чиг үүргийнхээ хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

46.1.1.шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг алдагдуулах үр нөлөөтэй хууль тогтоомжийг хүчингүй болгуулах болон шүүх эрх мэдлийн хүрээнд дагаж мөрдөх бусад хууль тогтоомж, эрх зүйн актын төсөл боловсруулах, санал өгөх, хууль санаачлагчид уламжлах;

46.1.2.Улсын дээд шүүхээс бусад шүүхийн байршлыг тогтоох, шүүх байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг судлан боловсруулж энэ хуульд заасан журмын дагуу шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

46.1.3.Улсын дээд шүүхээс бусад шүүхийн шүүгчийн орон тоо, бүх шатны шүүхийн шүүгчийн цалин хөлсний хэмжээг тогтоох тухай саналыг Улсын Их Хурал өргөн мэдүүлэх;

46.1.4.шүүхийн зохион байгуулалт, бүтцийг боловсронгуй болгох асуудлыг судалж, санал, шийдвэрийн төсөл боловсруулан холбогдох байгууллагад уламжлах;

46.1.5.Шүүгчийн эрх зүйн байдал, сахилга, хариуцлагын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу холбогдох ажиллагааг явуулах;

46.1.6.шүүхийн байрны эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх, холбогдох дүрэм, журам баталж мөрдүүлэх;

46.1.7.шүүгч, түүний гэр бүлийн гишүүний аюулгүй байдлыг хангах талаар шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь зохион байгуулах;

46.1.8.шүүх, шүүгчийн албаны болон ажил хэргийн нэр хүндийг хамгаалах.

46.1.9.хуульд заасан бусад.

46.2.Ерөнхий зөвлөл энэ хуулийн 46.1.8-т заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд туслах үүрэг бүхий нэгжийг ажлын албаныхаа бүтцэд тусгайлан зааж, чиг үүргийг нь энэ хуулийн 54.2-т заасан дүрэмд тодорхой тусгана.

47 дугаар зүйл.Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах

47.1.Ерөнхий зөвлөл шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах чиг үүргийнхээ хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

47.1.1.шүүхийн захиргаа, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон стандарт, дүрэм, журам батлан мөрдүүлэх;

47.1.2.шүүхийг хэвийн, тасралтгүй ажиллах зохион байгуулалтын нөхцөлөөр хангах;

47.1.3.шүүхийн тамгын газрыг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар, үйл ажиллагааны нийтлэг дүрмийг тогтоох, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

47.1.4.шүүхийн тамгын газар, шүүхийн төрөлжсөн төв архивд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

47.1.5.Ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Мэргэшлийн хорооны ажлын албаны дарга, Шүүхийн судалгаа, мэдээллийн байгууллагын дарга, шүүхийн тамгын газрын даргыг томилох, чөлөөлөх;

47.1.6.шүүхийн тамгын газрын ажлын үр дүн, түүний даргын ажил үүргийн хуваарийг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлэх;

47.1.7.шүүх дэх захиргааны албыг удирдаж, энэ талаар Төрийн албаны зөвлөлтэй хамтран ажиллах;

47.1.8.шүүх хуралдааны дуу авиа, дуу-дүрсний бичлэг хийх, тэдгээрийг архивлах болон хэргийн оролцогчийг шүүх хуралдаанд зайнаас оролцуулах ажлыг зохион байгуулах журмыг хуульд заасны дагуу батлах;

47.1.9.шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалт, мэдээлэл, лавлагаагаар хангах, аливаа нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, иргэдийн төлөөлөгчийн хориглосон үйлдэлд хяналт тавих, үйлдэл гарсан тохиолдолд холбогдох байгууллагад хандах;

47.1.10.шүүх дэх эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны зохион байгуулалтыг хангах;

47.1.11.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүртгэл, хяналтын нэгдсэн систем, программ хангамжийг хөгжүүлэх, хэвийн ажиллагааг хангах;

47.1.12.өөрийн эрх хэмжээний хүрээнд иргэдийн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч хянан шийдвэрлэх, энэ талаар шүүхийн тамгын газрын үйл ажиллагааг шалгах, хяналт тавих;

47.1.13.чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд Монголын Хуульчдын холбоо /цаашид “Хуульчдын холбоо” гэх/ болон бусад байгууллагатай харилцах, хамтран ажиллах;

47.1.14.шүүхийн тээвэр, холбоо, мэдээлэл шинжилгээ, программ хангамж, тэдгээрийн ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээг зохион байгуулах;

47.1.15.техник хэрэгсэл, түүнийг ашиглах мэргэжилтнээр хангаж, засвар үйлчилгээг зохион байгуулах;

47.1.16.шүүхийн нэгдсэн сүлжээнд шүүх болон шүүхийн захиргааны байгууллагыг холбож, түүнийг ашиглах техникийн нөхцөлөөр хангах;

47.1.17.хэргийн хөдөлгөөний удирдлагын чиг үүргийг дараах байдлаар хэрэгжүүлэх:

47.1.17.а.шүүхэд хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авч бүртгэх, шүүх хуралдаанд бэлтгэх стандарт, аргачлал, хэрэг, нэхэмжлэл хуваарилах нийтлэг журмыг баталж, удирдамжаар хангах;

47.1.17.в.хэргийн хөдөлгөөнийг судалж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бэлтгэл болон дараах үе шат тус бүрд зарцуулагдах хугацааны нэгдсэн стандартыг баталж мөрдүүлэх;

47.1.17.г.шүүхийн тогтоол, шийдвэр, шүүгчийн захирамж, шийтгэврийг нийтлэх, архивлахтай холбогдсон нэгдсэн стандарт, үлгэрчилсэн загварыг хуульд заасан журмын дагуу баталж мөрдүүлэх;

47.1.17.д.хэргийн хөдөлгөөний хяналтын болон мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх;

47.1.17.е.шүүх хуралдаан үргэлжлэх дундаж цагийн тооцоо гаргасны үндсэн дээр шүүх хуралдааны товыг хуульд заасан хугацаанд нийцүүлэн хэргийн оролцогчид хүрэлцэн ирэх боломжтойгоор оновчтой тогтоох аргачлал, журмыг баталж мөрдүүлэх;

47.1.17.ж.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрийг мэдээллийн санд бүртгэх, мониторинг хийх;

47.1.17.з.хэргийн хөдөлгөөний талаарх мэдээллээр шүүх болон олон нийтийг хангах.

47.1.18.шүүхийн тамгын газар хэргийн хөдөлгөөний удирдлагын чиг үүргээ хэрэгжүүлж байгаа байдалд дүн шинжилгээ хийх;

47.1.19.Монгол Улсын олон улсын гэрээ болон холбогдох хууль тогтоомжийн дагуу гадаад улсын адил түвшний байгууллага, эсхүл олон улсын байгууллагатай өөрийн эрх хэмжээний асуудлаар байгууллага хоорондын гэрээ байгуулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх;

47.1.20.хэргийн хөдөлгөөний хяналтын болон мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, бүх шатны шүүхүүдийн шүүх хуралдааны товыг нэгдсэн системд байршуулах;

47.1.21.хуульд заасан бусад бүрэн эрх.

48 дугаар зүйл.Шүүгчийг хуульчдаас шилж олох

48.1.Ерөнхий зөвлөл шүүгчийг хуульчдаас шилж олох чиг үүргийнхээ хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

48.1.1.шүүгчид нэр дэвшигчийг бүртгэх, сонгон шалгаруулах ажлыг Шүүгчийн эрх зүйн байдал, сахилга, хариуцлагын тухай хуульд заасан журмын дагуу зохион байгуулах;

48.1.2.шүүгчийг томилох болон шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, албан тушаалаас нь чөлөөлөх тухай саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх;

48.1.3.Мэргэшлийн хорооны үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах, дарга, гишүүдийг томилох, чөлөөлөх;

48.1.4.шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, шалгаруулах болон шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийн талаар дүгнэлт гаргах журам, шалгуурыг Мэргэшлийн хорооны саналыг үндэслэн батлах;

48.1.5.хуульд заасан бусад.

49 дүгээр зүйл.Шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах

49.1.Ерөнхий зөвлөл шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргийнхээ хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

49.1.1.Шүүгчийн эрх зүйн байдал, сахилга, хариуцлагын тухай хуульд заасан шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ажлыг хэрэгжүүлэх, зөрчигдсөн тодорхой тохиолдолд арга хэмжээ авах;

49.1.2.шүүгчийн хараат бус, халдашгүй байдалд сөргөөр нөлөөлсөн, шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх нөхцөл үүссэн тохиолдолд холбогдох арга хэмжээ авах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх;

49.1.3.энэ чиглэлээр Хуульчдын холбоотой хамтран ажиллах, зорилтод ажил, арга хэмжээ зохион байгуулах;

49.1.4.шүүх дэх авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хуульд заасны дагуу зохион байгуулах;

49.1.5.хуульд заасан бусад.

50 дугаар зүйл.Шүүхийн санхүү, эдийн засгийн баталгааг хангах

50.1.Ерөнхий зөвлөл шүүхийн санхүү, эдийн засгийн баталгааг хангах чиг үүргийнхээ хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

50.1.1.бүх шатны шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, энэ хуульд заасан журмын дагуу хүргүүлэх, өргөн мэдүүлэх;

50.1.2.шүүхийн төсвийг зориулалтын дагуу хуваарилан, төсвийн гүйцэтгэлийг үр ашигтай зохион байгуулах;

50.1.3.шүүхийн эдийн засаг, санхүү, хөдөлмөр, ажлын нөхцөлийн болон бусад баталгааг хангах ажлыг зохион байгуулах, шаардлагатай бол эдийн засаг, нийгмийн хамгааллын болон материал, техник хангамж зэрэг асуудлыг Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх;

50.1.4.шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах, мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх, олон нийтэд нээлттэй байлгах, аюулгүй байдлыг хангах стандартад нийцсэн шүүхийн байр, хуралдааны танхим болон бусад барилга байгууламж барих, засвар хийх хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг төлөвлөх, зураг төсвийг захиалан боловсруулж, гүйцэтгэлийг хангах;

50.1.5.шүүхийн санхүү, эдийн засаг, нягтлан бодох бүртгэлийн алба, ажлыг зохион байгуулж, хянан шалгаж удирдах;

50.1.6.шүүхийг орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангах нэгдсэн бодлого батлах, хэрэгжүүлэх;

50.1.7.шүүхийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг зохион байгуулж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээ авах;

50.1.8.хуульд заасан бусад.

50.2.Шүүх, шүүгч нь үйл ажиллагаагаа хараат бусаар явуулахад шаардагдах байнгын болон нүүдэллэн ажиллах байр, иргэдийг хүлээн авах, шүүх хуралдаан явуулах танхим, тээвэр, холбоо, мэдээллийн болон тусгай зориулалтын техник хэрэгсэл, тавилга, тоног төхөөрөмж, хамгаалалтаар хангагдсан байх бөгөөд тэдгээрийн стандарт, нөхцөлийг Шүүхийн ерөнхий зөвлөл тогтооно.

51 дүгээр зүйл.Шүүхийн хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх

51.1.Ерөнхий зөвлөл шүүхийн хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүргийнхээ хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

51.1.1.хүний нөөцийн бүртгэл, судалгаа, төлөвлөлт, хуваарилалт, хангалтыг зохион байгуулах;

51.1.2.шүүхийн захиалга, судалгаанд үндэслэн шүүхийн хүний нөөцийн хөдөлгөөнийг удирдах;

51.1.3.шүүхийн захиргааны байгууллагын ажилтны ажил хэргийн ур чадвар, мэргэшлийн түвшинг тодорхойлох шалгуур үзүүлэлт, журмыг тогтоож хэрэгжүүлэх;

51.1.4.шүүгч болон шүүхийн захиргааны ажилтны ажлын ачааллыг судалж, холбогдох арга хэмжээ авах, тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг энэ хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу хамгаалах;

51.1.5.шүүгч болон шүүхийн захиргааны ажилтныг дадлагажуулах, мэргэшлийг нь дээшлүүлэх сургалтыг Хуульчдын холбоо, Төрийн албаны зөвлөл болон сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулах;

51.1.6.хууль тогтоомжийн дагуу шүүхийн захиргааны ажилтныг төрийн шагнал, хүндэт цолд тодорхойлох.

51.1.7.хуульд заасан бусад.

52 дугаар зүйл.Шүүх болон олон нийтийг мэдээллээр хангах

52.1.Ерөнхий зөвлөл шүүхийг мэдээллээр хангах чиг үүргээ дараах байдлаар хэрэгжүүлнэ:

52.1.1.шүүхийн болон гэмт хэргийн статистик мэдээлэл гаргах;

52.1.2.шүүхийн статистикийн нэгдсэн тайлан, мэдээг гаргах, судлах, боловсруулалт хийх, бүх шатны шүүхэд хүргүүлэх;

52.1.3.шүүхийн шүүн таслах болон захиргааны ажлын практикийг судлах;

52.1.4.шүүхийн цахим болон бусад хэлбэрийн мэдээллийн сан бүрдүүлэх;

52.1.5.эрх зүйн онол, практикийн судалгаа, гарын авлага зэрэг албан хэрэгцээний сан бүрдүүлж, тогтмол шинэчлэх, ашиглалтыг зохион байгуулах.

52.1.6.хуульд заасан бусад.

52.2.Ерөнхий зөвлөл нь шүүхийг Монгол Улсын хуулийн албан ёсны эхээр тогтмол хангах болон хууль тогтоомжийн актын бүртгэл, лавламжийн ажлыг зохион байгуулна.

52.3.Ерөнхий зөвлөл болон шүүхийн тамгын газар дараах байдлаар олон нийтийг мэдээллээр хангана:

52.3.1.шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүхийг захиргааны удирдлагаар хангах, шүүгчдийг шилж олох, шүүгчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах бүрэн эрхийн хэрэгжилтийн талаар цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тогтмол мэдээлэх;

52.3.2.шүүхийн шийдвэр, тогтоолыг эмхэтгэн хэвлэх болон цахим хуудсанд тогтмол байрлуулах;

52.3.3.шүүхийн цахим хуудсыг тогтмол шинэчлэх;

52.3.4.мэдээлэл, лавлагааны үйлчилгээг зохион байгуулах;

52.3.5.шүүхийн үйл ажиллагааны талаар олон нийтийн саналыг бичгээр болон цахим хэлбэрээр авах ажлыг зохион байгуулах.

53 дугаар зүйл.Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа, нэр дэвшүүлэх, томилох журам

53.1.Ерөнхий зөвлөл арван гишүүнээс бүрдэх бөгөөд тэдгээр нь дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллана.

53.2.Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд шүүгчээр таваас доошгүй жил ажилласан анхан шатны шүүхийн шүүгч гурав, хяналтын шатны болон давж заалдах шатны шүүхийн шүүгч тус бүр нэг байх бол хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй, хууль зүйн өндөр мэргэшилтэй Монгол Улсын иргэн тав байна.

53.3.Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажиллах анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхийг шүүгчийг энэ хуульд заасан журмын дагуу Шүүгчдийн нэгдсэн зөвлөгөөнөөс санал болгоно.

53.4.Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажиллах энэ хуулийн 53.2-т заасан иргэний нэгийг Ерөнхийлөгч, нэгийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, гурвыг Хуульчдын холбоо санал болгоно.

53.5.Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд нэр дэвшүүлэх ажиллагаа нийтэд ил тод байх бөгөөд хууль зүйн шаардлага хангасан шүүгч болон иргэнд нэрээ дэвшүүлэх нийтлэг тэгш боломжийг олгосон байна.

53.6.Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг санал болгох эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас 45-аас доошгүй хоногийн өмнө нэр дэвшүүлэх тухай асуудлыг олон нийтэд зарлаж, нэрээ дэвшүүлэхэд тавих шаардлага болон бүртгэх, сонгон шалгаруулах хугацааг тодорхой заасан мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр түгээж, 15-аас доошгүй өдөр өөрийн цахим хуудсанд байршуулна.

53.7.Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг санал болгох эрх бүхий байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 53.6-д заасан хугацаанд бүртгүүлж, Ерөнхий зөвлөлийн гишүүнд нэрээ дэвшүүлсэн хүний зураг бүхий боловсрол, ажлын дадлага туршлага болон холбогдох бусад мэдээллийг агуулсан танилцуулгыг 15-аас доошгүй өдөр өөрийн цахим хуудсандаа байршуулж, олон нийтийн санал, сэтгэгдлийг хүлээн авах, харгалзан үзэх ажиллагааг зохион байгуулсаны үндсэн дээр сонгон шалгаруулна.

53.8.Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг санал болгох эрх бүхий байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 53.4-т заасан ажиллагааг хариуцах олон нийтийн хяналт бүхий ажлын хэсгийг байгуулж ажиллуулна.

53.9.Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажиллах энэ хуулийн 53.2-т заасан шүүгчийг бүртгэх, олон нийтийн санал, сэтгэгдлийг хүлээн авах ажиллагааг энэ хуулийн 53.6, 53.7-д заасны дагуу Шүүгчдийн хороо зохион байгуулж, нэр дэвшигийн талаарх олон нийтийн санал, сэтгэгдлийг Шүүгчдийн нэгдсэн зөвлөгөөнд нээлттэй танилцуулна.

53.10.Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг Улсын Их Хурал Нийтийн сонсголын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан томилгооны сонсголыг явуулсаны үндсэн дээр томилно. Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг санал болгох эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас 10-аас доошгүй хоногийн өмнө Улсын Их Хуралд саналаа ирүүлсэн байна.

53.11.Ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг нэр дэвшигчийг Улсын Их Хурал хуульд заасан үндэслэлээр томилохоос татгалзаж болох бөгөөд энэ тохиолдолд санал болгох эрх бүхий байгууллага, албан тушаалтан 14 хоногийн дотор энэ зүйлд заасан журмаар дахин нэр дэвшүүлж, томилно.

53.12.Ерөнхий зөвлөлийн гишүүд томилогдсоноос хойш долоо хоногийн дотор нийт гишүүдийн хуралдааныг зохион байгуулна.

53.13.Ерөнхий зөвлөлийн энэ хуулийн 53.12-т заасан хуралдааныг хамгийн ахмад настай гишүүн нь зарлаж, даргална.

53.14.Ерөнхий зөвлөлийн даргыг гишүүд нь дотроосоо нэр дэвшүүлж, нууц санал хураалтаар олонхийн санал авсан хүнийг сонгож тогтоол гаргана.

53.15.Ерөнхий зөвлөлийн гишүүн нь орон тооны байх бөгөөд төрийн өндөр албан тушаалтны зэрэг, зиндаа, түүнтэй адилтгах албан тушаалтны зэрэглэлд тохирсон цалин хөлс авч, зайлшгүй шаардлагатай бусад хангамж эдэлж, хуульд заасан баталгаагаар хангагдана.

53.16.Ерөнхий зөвлөлийн гишүүдийн гуравны хоёр нь бүрдсэнээр бүрэн эрхийн хугацаа эхэлж, бүрэлдэхүүнтэйд тооцогдоно.

53.17.Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон, эсхүл хугацаанаас өмнө чөлөөлөгдсөн бол дараагийн гишүүнийг энэ хуульд заасан журмын дагуу нөхөн томилно. Нөхөн томилогдсон гишүүн нь тухайн орон гарсан гишүүний бүрэн эрхийн хугацаанд ажиллана.

53.18.Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг тус зөвлөлийн өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.

53.19.Ерөнхий зөвлөлийн гишүүний ёс зүйн дүрмийг тус зөвлөл баталж, мөрдөнө.

54 дүгээр зүйл.Ерөнхий зөвлөлийн ажлын алба

54.1.Ерөнхий зөвлөл нь гишүүдийнхээ үүргийн гүйцэтгэлд туслалцаа үзүүлэх, Ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангах чиг үүрэг бүхий ажлын албатай байх бөгөөд Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нь ажлын албыг өдөр тутмын удирдлагаар хангана.

54.2.Ерөнхий зөвлөл батлагдсан төсвийн хүрээнд бүтэц, зохион байгуулалтаа өөрөө тогтоож, ажлын албаны үйл ажиллагааг дүрмээр зохицуулна.

54.3.Ерөнхий зөвлөлийн ажлын алба нь энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх мэргэшсэн нэгжээс бүрдэнэ.

54.4.Ерөнхий зөвлөлийн дэргэд иргэний болон захиргааны хэргийн хавтаст хэргийн төрөлжсөн төв архив, бүх шатны шүүхийн тамгын газарт түүний салбар архив ажиллана.

54.5.Энэ хуулийн 54.1-д заасан ажлын алба нь Ерөнхий зөвлөлийн тамга, тогтоосон загвараар үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудсыг зохих журмын дагуу хэрэглэнэ.

55 дугаар зүйл.Ерөнхий зөвлөлийн хуралдаан, түүнээс гарах шийдвэр

55.1.Ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь зөвлөлийн хуралдаан /цаашид “Хуралдаан” гэх/ байна.

55.2.Ерөнхий зөвлөл эрх хэмжээнийхээ асуудлыг энэ хуулийн 55.1-д заасан хуралдаанаар хэлэлцэн, олонхын саналаар шийдвэрлэж, тогтоол батална. Ерөнхий зөвлөл сард хоёроос доошгүй удаа хуралдана.

55.3.Ерөнхий зөвлөл хуралдааныхаа дэгийг өөрөө тогтооно.

55.4.Ерөнхий зөвлөлийн ээлжит бус хуралдааныг Ерөнхий зөвлөлийн даргын санаачилгаар, эсхүл гишүүдийн гуравны нэгээс доошгүйн шаардсанаар зарлан хуралдуулна.

55.5.Хуралдааныг гишүүдийн олонх нь хүрэлцэн ирсэнээр хүчинтэйд тооцох бөгөөд хуралдааныг нээлттэй зохион байгуулж, шүүгчийг хуульчдаас шилж олох асуудлыг нууц, бусад асуудлаар ил санал хураалтаар шийдвэрлэнэ.

55.6.Ерөнхий зөвлөлийн дарга гарын үсэг зурж, тамга дарснаар энэ хуулийн 55.2-т заасан тогтоол хүчин төгөлдөр болно.

56 дугаар зүйл.Ерөнхий зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлага, гишүүний үүрэг, хориглох зүйл

56.1.Ерөнхий зөвлөлийн гишүүн энэ хуулийн 53.2-т зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

56.1.1.эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй;

56.1.2.шударга зан чанар, өндөр ёс зүйтэй;

56.1.3.шүүгчид нэр дэвшигчийн болон Ерөнхий зөвлөлөөс томилох бусад албан тушаалтны мэдлэг, ур чадвар, туршлагыг аливаа нөлөөнд үл автан бодитой үнэлэх чадавхтай байх;

56.1.4.ашиг сонирхлын зөрчилгүй байх;

56.1.5.улс төрийн намын удирдах, гүйцэтгэх албан тушаалд сүүлийн 1 жилийн хугацаанд ажиллаагүй байх.

56.2.Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг санал болгох эрх бүхий байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 56.1.-д заасан шаардлагын талаар холбогдох байгууллагаас дүгнэлт, лавлагаа, мэдээлэл, тодорхойлолт гаргуулна.

56.3.Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүн хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, шударга, хараат бус байх, бодитой хандах, хууль дээдлэх, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, ийм нөхцөл үүссэн бол татгалзан гарах, Ерөнхий зөвлөлийн гишүүний ёс зүйн дүрмийг чандлан сахих үүрэгтэй.

56.4.Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүнд дараах зүйлийг хориглоно:

56.4.1.энэ хуулийн 53.3-т заасны дагуу сонгогдсоноос бусад гишүүн Ерөнхий зөвлөлийн бүрэн эрхийн хугацаанд болон уул хугацаа дуусгавар болсноос хойш гурван жилийн дотор шүүгчид нэр дэвших;

56.4.2.ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, эсхүл өөрт хамаарал бүхий этгээдтэй холбоотой шийдвэр гаргахад оролцох;

56.4.3.албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн нууцыг задруулах, хувийн ашиг сонирхлыг хангах зорилгоор ашиглах;

56.4.4.улс төрийн үйл ажиллагаа явуулах;

56.4.5.шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх;

56.4.6.Шүүхийн сахилгын хороо болон Шүүхийн мэргэшлийн хорооны дарга, гишүүнд нөлөөлөх;

56.4.7.Ерөнхий зөвлөлийн гишүүний үүрэг гүйцэтгэхтэй холбогдуулан бэлэг, шан харамж авах.

57 дугаар зүйл. Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрх

57.1.Ерөнхий зөвлөлийн гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

57.1.1.Ерөнхий зөвлөлийн бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх чиг үүргийг хариуцах;

57.1.2.Ерөнхий зөвлөлийн хуралдаанаар тодорхой асуудал хэлэлцүүлэх санал оруулах;

57.1.3.Ерөнхий зөвлөлийн хуралдаанд таслах эрхтэй оролцох;

57.1.4.Ерөнхий зөвлөлийн шийдвэрийн биелэлтийг хангуулах;

57.1.5.Ерөнхий зөвлөлийн хуралдааныг зарлан хуралдуулахаар шаардах;

57.1.6.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

58 дугаар зүйл.Ерөнхий зөвлөлийн даргын бүрэн эрх

58.1.Ерөнхий зөвлөлийн дарга нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

58.1.1.Ерөнхий зөвлөлийг тэргүүлж, түүнийг дотоод гадаадад төлөөлөх, үйл ажиллагааны ерөнхий удирдлагыг хэрэгжүүлэх;

58.1.2.өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, холбогдох бусад байгууллага, албан тушаалтантай харилцах;

58.1.3.Улсын Их Хурлын нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаан, Засгийн газрын хуралдаанд Ерөнхий зөвлөлийн байр суурийг илэрхийлэх, төсвийн болон бусад асуудлыг шийдвэрлүүлэх;

58.1.4.Ерөнхий зөвлөлийн хуралдааныг товлох, даргалах, хуралдааны бэлтгэл, түүний шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;

58.1.5.Ерөнхий зөвлөлийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавих;

58.1.6.Ажлын алба, шүүхийн тамгын газрын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах

58.1.7.Ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, шүүхийн тамгын газрын даргад нэр дэвшүүлэх, сахилгын шийтгэл ногдуулах;

58.1.8.Ерөнхий зөвлөлийн ажлын тайланг Улсын Их Хурал болон Монгол Улсын Ерөнхийлөгчид жил бүр танилцуулах;

58.1.9.Ерөнхий зөвлөлийн ажлын тайланг бүх шатны шүүхэд хүргүүлэх;

58.1.10.Ерөнхий зөвлөлийн ажлын албыг ерөнхий удирдлагаар хангах;

58.1.11.Ерөнхий зөвлөлийн гишүүнийг энэ хуульд заасан чөлөөлөх эсхүл огцруулах үндэслэл бий болсон тохиолдолд хойш ажлын 10 өдрийн дотор санал болгосон буюу томилсон байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх;

58.1.12.шүүхийн төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэвийг холбогдох журмын дагуу олгох

58.1.13.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

58.2.Ерөнхий зөвлөлийн дарга нь Ерөнхий зөвлөлийн ажлын алба, аймаг, нийслэл, сум, сум дундын, дүүргийн болон дагнасан шүүхийн төсвийн ерөнхийлөн захирагч байна.

58.3.Ерөнхий зөвлөлийн дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Засгийн газрын гишүүнтэй адил бүрэн эрхийн баталгаа, хангамжтай байна.

58.4.Ерөнхий зөвлөлийн даргын түр эзгүйд түүний үүргийг хамгийн ахмад настай гишүүн нь орлон гүйцэтгэнэ.

58.5.Ерөнхий зөвлөлийн дарга эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргана.

59 дүгээр.Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх, огцруулах, эгүүлэн татах

59.1.Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүнийг дараах үндэслэлээр үүрэгт ажлаас нь чөлөөлнө:

59.1.1.бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон;

59.1.2.тэтгэврийн насанд хүрсэн болон эрүүл мэндийн байдал, бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон;

59.1.3.өөрөө хүсэлт гаргасан болон өөр ажил, албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон.

59.2.Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүнийг дараах үндэслэлээр огцруулна:

59.2.1.хуралдааныг удаа дараа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан;

59.2.2.ёс зүйн ноцтой алдаа гаргасан;

59.2.3.гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон.

59.3.Ерөнхий зөвлөлийн гишүүнийг санал болгосон байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 59.2-т заасан үндэслэлээр эгүүлэн татаж болно.

60 дугаар зүйл.Ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга, түүний бүрэн эрх

60.1.Ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга нь Ерөнхий зөвлөлийн ерөнхий менежер, ажлын албаны төсвийн шууд захирагч байх бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

60.1.1.Ерөнхий зөвлөлийн ажлын албыг өдөр тутмын удирдлагаар хангах;

60.1.2.Ерөнхий зөвлөлийн ажлын албаны ажилтныг томилох, чөлөөлөх;

60.1.3.Ерөнхий зөвлөлийн ажлын албаны төсвийг захиран зарцуулах, тайлагнах;

60.1.4.Ерөнхий зөвлөлийн ажлын албаны үйл ажиллагааны тайланг Ерөнхий зөвлөлд тайлагнах;

60.1.5.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

60.2.Ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн даргаар хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, Төрийн албаны тухай хуулийн 23.2.1-д заасан тэргүүн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн байна.

60.3.Гүйцэтгэх нарийн бичгийн даргыг Ерөнхий зөвлөлийн даргын санал болгосноор Ерөнхий зөвлөл томилж, чөлөөлнө.

60.4.Гүйцэтгэх нарийн бичгийн дарга бүрэн эрхийнхээ асуудлаар тушаал гаргана.

60.5.Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нь үйл ажиллагаагаа Ерөнхий зөвлөлд хариуцан тайлагнана.

61 дүгээр зүйл.Шүүхийн мэргэшлийн хороо

61.1.Шүүхийн мэргэшлийн хороо /цаашид “Мэргэшлийн хороо” гэх/ улсын хэмжээнд нэг байна.

61.2.Мэргэшлийн хороо нь орон тооны бус есөн гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд тэдгээр нь дөрвөн жилийн хугацаагаар нэг удаа ажиллана.

61.3.Мэргэшлийн хороо нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, хууль зүйн буюу шүүн таслах ажлын туршлагатай, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан шүүгч, эрдэмтэн, хуульчаас бүрдэх бөгөөд Мэргэшлийн хорооны гишүүдийг Хуульчдын холбооны санал болгосноор Ерөнхий зөвлөл томилж, чөлөөлнө.

61.4.Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнд, анхан шатны шүүгч, Ерөнхий зөвлөлийн болон шүүхийн захиргааны байгууллагын ажилтан, өмгөөлөгч, прокурор орохыг хориглоно.

61.5.Мэргэшлийн хорооны даргыг гишүүдийнх нь саналыг үндэслэн Ерөнхий зөвлөл томилж, чөлөөлнө.

61.6.Мэргэшлийн хороо шүүгч, Ерөнхий шүүгчид нэр дэвшигчээс Шүүгчийн эрх зүйн байдал, сахилга, хариуцлагын тухай хуульд заасан шалгалт авч, үнэлгээ өгөх, Шүүхийн сахилгын хорооны тогтоолыг үндэслэн шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшинг тогтоож дүгнэлт, зөвлөмж гаргах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

61.7.Мэргэшлийн хорооны энэ хуулийн 61.6-д заасан дүгнэлт шүүгчийг ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийн хувьд албан тушаалдаа тэнцэхгүй гэж гаргасан бол Ерөнхий зөвлөлд хүргүүлнэ.

61.8.Мэргэшлийн хорооны үйл ажиллагааны болон гишүүний ёс зүй, сонирхлын зөрчлийн дүрмийг Ерөнхий зөвлөл баталж мөрдүүлнэ.

61.9.Мэргэшлийн хорооны гишүүн нь хараат бусаар үйл ажиллагаагаа явуулж, аливаа шударга бус үйлдэл, сонирхлын зөрчил, өөртөө давуу байдал бий болгох зэрэг ёс зүйн алдаа гаргахаас сэргийлэх үүрэгтэй.

61.10.Мэргэшлийн хорооны гишүүний үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

61.10.1.шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс оролцох;

61.10.2.шүүгчийн хараат бус байдалд аливаа хэлбэрээр нөлөөлөх;

61.10.3.нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтын материал болон үнэлгээ, шалгалтын материалыг урьдчилан ил болгох, тодорхой нэр дэвшигчийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр байр сууриа илэрхийлэх;

61.10.4.нэр дэвшигчийн үнэлгээг үндэслэлгүйгээр өөрчлөх;

61.10.5.Мэргэшлийн хорооны гишүүнээр ажиллаж байх хугацаандаа болон гишүүнээс чөлөөлөгдсөнөөс хойш гурван жилийн дотор шүүгчийн албан тушаалд нэр дэвших.

61.11.Мэргэшлийн хороо бие дааж, хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг Ерөнхий зөвлөл бүрдүүлнэ.

61.12.Мэргэшлийн хороо нь орон тооны ажлын албатай байна. Шүүгчид нэр дэвшигчийн эрх зүйн мэдлэг болон шүүгчийн мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварыг шалгаж, дүгнэлт гаргахад шаардлагатай материал бүрдүүлэх, материалыг судлах, шалгалт авах ажлыг зохион байгуулах, нэр дэвшигчийг товлосон цагт бэлэн байлгах зэрэг Мэргэшлийн хороонд туслахад чиглэсэн зохион байгуулалтын ажлыг Мэргэшлийн хорооны ажлын алба хариуцна.

61.13.Мэргэшлийн хорооны ажлын алба нь Ерөнхий зөвлөлийн ажлын албанд харьяалагдана.

62 дугаар зүйл.Шүүхийн тамгын газар

62.1.Шүүх тамгын газартай байна.

62.2.Бүх шатны шүүхийн тамгын газар үйл ажиллагаагаа Шүүхийн ерөнхий зөвлөлд тайлагнана.

62.3.Шүүхийн тамгын газрын бүтэц, орон тоог тухайн шүүхийн ажлын ачаалал, онцлогийг харгалзан Шүүхийн ерөнхий зөвлөл батална.

62.4.Бүх шатны шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл тогтооно.

62.5.Шүүхийн тамгын газар нь тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

63 дугаар зүйл.Шүүхийн тамгын газрын чиг үүрэг

63.1.Шүүхийн тамгын газар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

63.1.1.энэ хуулийн 45, 46, 47, 49, 51, 52-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд тухайн шүүх дээр холбогдох ажлыг зохион байгуулах;

63.1.2.шүүхийг өдөр тутмын үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлөөр хангах;

63.1.3.шүүхийн хөдөлмөр зохион байгуулалт, дотоод журмын биелэлтэд хяналт тавих;

63.1.4.шүүхэд хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, бүртгэх;

63.1.5.шүүхийн бичиг хэрэг, захидал харилцаа, шуудан, архивын үйл ажиллагааг зохион байгуулах;

63.1.6.шүүхийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг зохион байгуулж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээ авах;

63.1.7.хэргийн эд мөрийн баримтыг хадгалах, зөөвөрлөх, шийдвэрлэх,

63.1.8.тухайн шүүхийн шүүн таслах болон бусад ажиллагааны тоон мэдээлэл гаргах.

64 дүгээр зүйл.Шүүхийн тамгын газрын даргын бүрэн эрх

64.1.Шүүхийн тамгын газрын дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

64.1.1.шүүхийн тамгын газрыг өдөр тутмын удирдлагаар хангах;

64.1.2.шүүхийн тамгын газрын ажилтныг томилох, чөлөөлөх;

64.1.3.шүүхийн тамгын газрын төсвийг захиран зарцуулах, тайлагнах;

64.1.4.шүүхийн тамгын газрын ажлын тайланг тухайн шүүхдээ танилцуулах;

64.1.5.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

64.2.Шүүхийн тамгын газрын дарга эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргана.

64.3.Шүүхийн тамгын газрын дарга үйл ажиллагаагаа Шүүхийн ерөнхий зөвлөлийн өмнө хариуцан тайлагнана.

64.4.Шүүхийн тамгын газрын даргын бүрэн эрхийг Ерөнхий шүүгч болон шүүгч хэрэгжүүлэхийг хориглоно.

65 дугаар зүйл.Шүүхийн судалгаа, мэдээллийн байгууллага

65.1.Ерөнхий зөвлөл энэ хуулийн 52 дугаар зүйлд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүрэг бүхий шүүхийн судалгаа, мэдээллийн байгууллагатай байна.

65.2.Шүүхийн судалгаа, мэдээллийн байгууллагын чиг үүрэг, бүтэц, орон тоо, ажиллах журмыг Ерөнхий зөвлөл тогтоож, биелэлтийг зохион байгуулна.

65.3.Шүүхийн судалгаа, мэдээллийн байгууллагын даргыг Ерөнхий зөвлөл томилж, чөлөөлнө.

67 дугаар зүйл.Шүүхийн захиргааны ажилтан

67.1.Шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүхийн тамгын газрын ажилтан нь шүүхийн захиргааны ажилтан байна.

67.2.Шүүхийн захиргааны ажилтан дараах шаардлагыг хангасан байна:

67.2.1.Монгол Улсын иргэн байх;

67.2.2.Төрийн албаны тухай хууль болон бусад хуульд заасан болзол, шаардлагыг хангасан байх;

67.2.3.эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй;

67.2.4.хуульд заасан ёс зүйн шаардлагыг хангасан байх;

67.2.5.тухайн ажил үүргийг гүйцэтгэх мэдлэг, боловсрол, туршлагатай байх.

68 дугаар зүйл.Шүүгчийн туслах

68.1.Шүүгч туслахтай байх бөгөөд шүүгчийн туслах эрх зүйч мэргэжилтэй хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан байна.

68.2.Шүүгчийн туслах шүүгчийн удирдлага дор хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

68.2.1.шүүхэд ирүүлсэн тодорхой хэрэг, маргааны талаарх бичиг баримтын бүрдлийг судалж, шүүгчид танилцуулах;

68.2.2.хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан шүүгчээс даалгасан ажиллагааг гүйцэтгэх;

68.2.3.шүүгчийн үйл ажиллагаанд техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх;

68.2.4.хэрэг, маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай хууль тогтоомжийн талаар болон бусад мэдээлэл бэлтгэх зэргээр шүүгчид туслах;

68.2.5.хавтаст хэргийг хөтлөх;

68.2.6.тодорхой хэрэг, маргааны талаарх мэдээллийг нэгдсэн цахим санд оруулах;

68.2.7.шүүх хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хангахад оролцох;

68.2.8.шүүхийн шийдвэр, тогтоол, шүүгчийн захирамжийн төсөл боловсруулах;

68.2.9.тэмдэгтийн хураамж төлөгдсөн эсэхийг хянах;

68.2.10.хууль тогтоомж, ажлын байрны тодорхойлолтод заасан бусад чиг үүрэг.

68.3.Шүүгчийн туслахаар ажилласан жилийг мэргэжлээрээ ажилласанд тооцно.

69 дүгээр зүйл.Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга

69.1.Бүх шатны шүүхэд шүүх хуралдааны нарийн бичгийн дарга ажиллах бөгөөд нарийн бичгийн дарга эрх зүйч мэргэжилтэй байна.

69.2.Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга шүүх хуралдааныг даргалагчийн удирдлага доор дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

69.2.1.шүүх хуралдааны техник, зохион байгуулалтын бэлтгэлийг хангах;

69.2.2.шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөх;

69.2.3.шүүх хуралдааныг дуу болон дуу-дүрсний бичлэгээр баталгаажуулах;

69.2.4.шүүх хуралдааны тэмдэглэлийг хэргийн оролцогчид хуульд заасан хугацаанд танилцуулан, шүүгчээр баталгаажуулж, хэрэгт хавсаргах;

69.2.5.Ажлын байрны тодорхойлолтод заасан бусад чиг үүрэг.

69.3.Шүүх хуралдааны тэмдэглэлийг мэдээллийн технологийн тусламжтайгаар бичиж болно.

70 дугаар зүйл.Шүүхийн захиргааны бусад ажилтан

70.1.Шүүхийн зохион байгуулалт, мэдээлэл зүйн болон аж ахуй, санхүү, архив, бичиг хэргийн ажил, аюулгүй байдал, техникийн үйлчилгээ зэргийг хариуцсан шүүхийн тамгын газрын ажилтны чиг үүргийг Шүүхийн ерөнхий зөвлөл тогтооно.

70.2.Шүүхийн захиргааны ажилтан энэ хуульд заасан чиг үүргээс гадна хэрэг, маргаан хянан шийдвэрлэх холбогдох хуульд заасан тусгай эрх, үүрэг болон төрийн захиргааны албан хаагчийн хувьд төрийн албаны тухай хууль тогтоомжид заасан нийтлэг эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

71 дүгээр зүйл.Шүүхийн захиргааны ажилтны ёс зүй

71.1.Шүүхийн захиргааны ажилтан төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг дүрэм, хэм хэмжээг мөрдөж, дараах шаардлагыг биелүүлж ажиллана:

71.1.1.шүүхэд хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэг, маргааны талаар тухайн хэргийн оролцогч, сонирхогч этгээдэд зөвлөгөө, мэдээлэл өгөхгүй, аливаа хэлбэрээр бусдад зуучлахгүй байх;

71.1.2.шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй хэрэг, маргааны талаар хувийн таамаглал, урьдчилсан дүгнэлтээ бусдад илэрхийлэхгүй байх;

71.1.3.хэргийн оролцогчидтой хувийн харилцаа тогтоохгүй байх;

71.1.4.ажлын бус цагаар шүүхийн нэр хүндэд харшлах аливаа зохисгүй үйлдэл гаргахгүй байх;

71.1.5.шүүх болон шүүхийн байгууллагад ажиллаж байгаадаа хүндэтгэлтэй хандаж, ажлын байр, олон нийтийн дунд биеэ зөв авч явах.

72 дугаар зүйл.Шүүхийн захиргааны ажилтны ёс зүйн зөрчилд гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх

72.1.Шүүхийн захиргааны ажилтан мэргэжил, ёс зүйн зөрчил гаргасан гэж үзсэн этгээд тухайн шүүхийн тамгын газрын даргад гомдол гаргана.

72.2. Ёс зүйн зөрчил гаргасан шүүхийн захиргааны ажилтанд Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу эрх бүхий албан тушаалтан сахилгын шийтгэл оногдуулна.

73 дугаар зүйл. Шүүхийн захиргааны ажилтны сургалт

73.1. Шүүхийн захиргааны ажилтан Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан мэргэжлийн сургалтад хамрагдана.

74 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

74.1. Энэ хуулийг 2020 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ